

---

---

# МЕНИНГОКОККТ ХАЛДВАР

---


---

Ч.Уртнасан, ХӨСҮТ, ТҮН

## Менингококкт халдвар

- Дэлхий дахинд жилд дунджаар
  - 500,000-1,200,000 тохиолдол
  - 50,000-135,000 нас баралт бүртгэгддэг байна.
- Өмнөд Америк, Австралид
  - 100,000 хүн амд 0.3-3 тохиолдол
- Африкийн орнуудад /менингококкт халдварын бүс нутаг/
  - 100,000 хүн амд 10-1,000 тохиолдол бүртгэгддэг байна.
- Ази болон Латин Америкийн улс орнуудын өвчлөлийн талаарх мэдээлэл харьцангуй хомс байна.

# Дэлхий дахинд тодорхойлогдсон дэд хэвшинж



- Өвчлөл 5 хүртэлх насны хүүхдүүдийн дунд хамгийн өндөр хувьтай бүртгэгддэг ба дараа нь насанд хүрэгсэд, идэр насны (15-25 нас) хүмүүс байна.
- Европын орнуудад
  - МенВ – 5 хүртэлх насны хүүхдүүд
  - МенС – 25-44 насны хүмүүс
  - МенҮ – 65 болон түүнээс дээш насны хүмүүсийг илүү өвчлүүлдэг.
- 0-11 сартай хүүхдүүд илүү хүндэрч, нас барах өндөр эрсдэлтэй байдаг.

## Монгол улсад бүртгэгдэж буй менингококкт халдварын өвчлөлийн байдал

---

- 1969-2015 онд 28,189 тохиолдол, 3,582 нас баралт
- 1950 оноос хойш 3 удаагийн эпидеми
  - 1951-1959 онд: 9.8 тохиолдол (10,000 хүн амд)
  - 1972-1974 онд: 19.4 тохиолдол
  - 1992-1994 онд: 14.0 тохиолдол
- Эпидеми хоорондын зай **15-21** жил
- Сүүлийн үечилсэн давталтаас хойш **23** жил болж байна.

# Хэтийн төлөв


---

- 1951-2008 оны хугацаанд бүртгэгдсэн менингококкт халдварын 10,000 хүн амд ногдох өвчлөлийг хугацааны Mini Tab программаар хэтийн төлөвийг тодорхойлход 2009-2010 онд харьцангуй ихсэж, 2014-2016 онд дэгдэлтийн байдалд орж 10,000 хүн ам тутмаас 14.9-20.0 хүн өвчлөх хандлагатай.

Н.Цэнд, Н.Уртнасан, Ч.Дашцэрэн, Л.Дондог, Н.Наряд (2006) Дэлхийн ба Монгол дахь менингококкт халдварын эпидемиологийн шинж

төрх, урьдчилан сэргийлэлт

## Менингококкт халдварын хэтийн төлөв



## Менингококкт халдварын 2013-2022 он хүртлэх прогноз /10,000 хүн амд/

№	Он	Менингококкт халдвар (10,000 хүн амд)
1	2013	2.7
2	2014	9.0
3	2015	14.9
4	2016	20.1
5	2017	13.3
6	2018	8.5
7	2019	5.1
8	2020	3.7
9	2021	2.3
10	2022	2.3

# Дархлаажуулалт

---

№	Он	Нас	Тоо
1	1994	2-18	20,595
2	1995	6-18	17,846
3	1998	2-15	188,212
4	2008	2-14	291,474
5	2011	16-25	19,806
6	2013	2-16	2,216



# **Менингококкт халдварын өвчлөлийн байдал**

# Менингококкт халдварын хөдлөлт, бодит тоогоор, долоо хоног

Тохиолдлын тоо

2

1


0

1 3 5 7 9 11 13 15 17 19 21 23 25 27 29 31 33 35 37 39 41 43 45 47 49 51 | 1 3 5 7 9 11 13 15 17 19 21 23 25 27 29 31 33 35 37 39 41 43 45 47 49 51 | 1 3 5 7 9 11

2015 он

2016 он


2017




# Менингококкт халдварын өвчлөлийн байдал, эхний 3 сараар

Он	Өвчлөл /бодит тоогоор/	Өвчлөлийн түвшин /10,000 хүн амд/	Нас баралт	Үхлийн түвшин
2012 он	9	0.03	0	0.0
2013 он	13	0.05	4	30.8
2014 он	4	0.01	1	25.0
2015 он	3	0.01	0	0.0
2016 он	6	0.02	0	0.0
2017 он	6	0.02	1	16.7


# Менингококкт халдварын улиралчлалын байдал







# 2012-2017 онд бүртгэгдсэн менингококкт халдвар, насны бүлгээр



# 2012-2017 онд бүртгэгдсэн менингококкт халдвар, нийгмийн байдал



# Өвчлөл, газарзүйн байршлаар, эхний 3 сарын байдлаар



2016 он

2017 он

# 2017 оны эхний 3 сард бүртгэгдсэн өвчлөл

Тохиолдол	Нас	Онош	Шинж тэмдэг эхэлснээс хойш эрүүл мэндийн байгууллагад хандсан хугацаа (цаг)	Эмнэлэгт хандсанаас хойш онош тавьсан хугацаа (цаг)	Өвчний шинж тэмдэг эхэлснээс хойш онош батлагдсан хугацаа (цаг)	Хандсан эрүүл мэндийн байгууллагууд	Шинжилгээнд үүсгэгч илэрсэн байдал	Ирэх үеийн биеийн байдал	Эмнэлзүйн шинж тэмдэг	Нас барсан
1	3.8	A39.4	8	37.3	37.4	ӨЭМТ-103-БОЭТ хүлээн авах-Хувийн эмнэлэг-БОЭТ	грамм сөрөг хос кокк	Маш хүнд	Өндөр халуурах, цочромтгой болох, хоолонд дургүй болох, бөөлжих, суулгах, цусархаг, үхжилт тууралт гарах-100%, хүзүү хөших, зулай чинэрэх-83%	Үгүй
2	3	A39.4	6	30	36	Дорнод БОЭТ-Хүүхдийн тасаг	грамм сөрөг хос кокк	Хүнд		Үгүй
3	6	A39.4, A39	2.3	24.3	26.6	Дорнод ӨЭМТ-ӨЭМТ-БОЭТ-халдвартын тасаг	N.meningitidis	Хүнд		Үгүй
4	1.6	A39.4	3	10	13	СХД 103-ӨЭМТ-ӨЭМТ-ХЭСҮТ	N.Meningitidis Ү	Маш хүнд		Тийм
5	1.2	A39.4	5.2	10.2	15.4	ЧД 103-ӨЭМТ-ХЭСҮТ	N.meningitidis	Хүнд		Үгүй
6	2.2	A39.4	0.45	70	70.5	Дархан-Уул аймгийн 103-ӨЭМТ-НЭ хүүхдийн тасаг	N.meningitidis	Маш хүнд		Үгүй
	<b>Дундаж нас 2.9</b>	<b>A39.4-6, хавсарсан -1</b>	<b>4.3</b>	<b>30.3</b>	<b>33.1</b>	<b>3-5 дамжсан</b>	<b>N.men -4/66% Ү хүрээ -1</b>	<b>50%-маш хүнд, 50% хүнд</b>		<b>1 нас баралт</b>



# 2011-2017 онд тодорхойлогдсон үүсгэгчийн хүрээ

Он	Хүрээ /тохиолдол/
2011	B /4/
2012	B /1/; W135 /1/
2013	W135 /1/
2014	B /1/
2015	B /4/
2016	B /1/
2017	Y /1/

## Голомтонд авсан арга хэмжээ

Тохиолдол	Хавьтлын тоо	Хими сэргийлэлт	Вакцин	Назофарингитийн үзлэг	Хөөмийн арчдас
1	21	20	20	20	0
2	17	17	17	17	13
3	431	399	150	431	32
4	22	22	20	22	0
5	19	19	18	19	15
6	3	3	0	3	2
<b>Нийт</b>	<b>513</b>	<b>480</b>	<b>225</b>	<b>512</b>	<b>62</b>

# ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ

- ЭМС-ын 2017 оны 3-р сарын 10-ны 1 тоот албан даалгавар,
- Аймаг, нийслэлийн ЭМГ-т ХӨСҮТ-ийн ерөнхий захирлын албан тоотоор зөвлөмж,
- Цахим сургалтыг 21 аймаг, нийслэлийн ЭМГ, НЭ, БОЭТ-ийн дарга, эмчилгээ эрхэлсэн орлогч, халдварт, хүүхэд, тархвар судлаач, яаралтай түргэн тусламж, эрчимт эмчилгээний болон өрхийн эмч нарт
- Нийслэлийн ЭМГ-ын харьяа түргэн тусламжийн болон өрхийн эмч нарт сургалт зохион байгуулах
- Нийслэлийн сургууль, цэцэрлэгийн эмч нарт сургалт зохион байгуулах
- Ард иргэдэд зориулсан зөвлөмж, санамж, зурагт хуудас тараах
- Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сургалт, сурталчилгааг явуулах
- Инфографикийг байгууллагын вэбсайтад байршуулах
- Сошиалаар зөвлөмж өгөх, хариу арга хэмжээний эргэн мэдээлэл
- 24 цагийн утсаар ард иргэдийн асуултанд хариулах

# Цаашид анхаарах болон хэрэгжүүлэх арга хэмжээ

---

- Эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагууд нь Эрүүл мэндийн сайдын 2008 оны 37 дугаар тушаалын зааврыг мөрдөн, менингококкт халдвартай тэмцэх, сэргийлэх арга хэмжээг авч эрчимжүүлэх төлөвлөгөө гарган, хэрэгжүүлэх,
- Менингококкт халдварын эмнэлзүй, ялган оношлогоо, эмчилгээ, голомтонд хариу арга хэмжээ авах талаар эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулах (ялангуяа шинэ төгссөн залуу, резидент эмч нарт)
- Хугацаа алдалгүй эмнэлгийн тусламж үйлчилгээг нэн тэргүүн хүргэх тал дээр анхааралтай хандах,
- Менингококкт халдварыг оношлох лабораторийн урвалж, оношлуур, тоног төхөөрөмж, голомтонд хэрэглэх эм (ципрофлоксацин, рифампицин)-ийн нөөцийг сэлбэж, халдварын сэжиг илэрсэн үед эмчилгээ эхлэхээс өмнө лабораторид сорьц авч шинжлэн, оношийг баталгаажуулах,

- Сургуулийн өмнөх болон сургуулийн багш, эцэг, эхчүүдэд менингококкт халдвараас сэргийлэх, илрэх эмнэлзүйн шинж тэмдгийн талаар хичээл заах, сурталчилгаа хийх,
- Сургууль, цэцэрлэг, хүүхдийн байгууллагын эмч нар нь сурагч, хүмүүжигч, багш, ажилчдын дунд хамар залгиурын цочмог, архаг үрэвсэлт өвчнийг илрүүлэх, эрүүлжүүлэх ажлын төлөвлөгөө гарган, хэрэгжүүлж ажиллах,
- Багш, ажилчид болон хүүхдийг амны хөндий, хоолой цэвэршүүлэх аргад сургах сургалт, сурталчилгааг явуулах,
- Тууралтат халдварын сэжигтэй тохиодол гарсан үед 24 цагийн дотор ХӨСҮТ-ийн 454921, 451798, 100 тоот утсанд мэдээлэх,